

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2019

## ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛД: ӨРСӨЛДӨХ ЧАДВАР, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ БОЛОН БИЗНЕСИЙН ОРЧИН

Доожавын Ган-Очир<sup>1</sup>

*JEL ангилал:*

R10, R11, R51

*Түлхүүр үг:*

Аймгийн өрсөлдөх чадвар,  
санхүүгийн зах зээл,  
бизнесийн орчин, нийгэм,  
эдийн засгийн хөгжил

*Хураангуй:*

Энэхүү судалгааны өгүүллээр Увс аймгийн өрсөлдөх чадвар, санхүүгийн зах зээл болон бизнесийн орчинд үнэлгээ хийж, тус аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгахад цаашид анхаарах асуудлаар дүгнэлт хийж, санал, зөвлөмж гаргалаа.

### 1. Удиртгал

Эдийн засгийн хөгжил нь цөөн тооны салбар, үйлдвэрлэлийг санхүүжилтээр дэмжсэнээр богино хугацаанд бий болдоггүй, харин харилцан уялдаатай олон хүчин зүйл (институци, бодлого, интеграци, соёл болон газар зүйн байршил гэх мэт)-ийн нийлбэр нөлөөллийн урт хугацааны үр дүн юм. Харин эдийн засгийн тогтвортой, өндөр өсөлтийг бий болгохын тулд бодлого боловсруулагчдын нөлөөлж чадах хоёр хүчин зүйл нь: 1) шаардлагатай сайн бодлогыг хэрэгжүүлэх; 2) институци, засаглалыг сайжруулах явдал юм. Эдийн засгийн тогтвортой өсөлт нь хөгжлийг бий болгох зайлшгүй нөхцөл боловч дангаараа хүрэлцээтэй нөхцөл биш юм. Гагцхүү эдийн засгийн тогтвортой, өндөр өсөлтийг хангаж чадсанаар хүний хөгжил, эдийн засгийн хөгжлийн суурь орчныг бүрдүүлж, ядуурлын түвшин буурах боломж бүрдэнэ. Улс орон хөгжлийн сорилтоо даван туулж, боломжоо бүрэн ашиглахад орон нутгийн гүйцэтгэх үүрэг чухал юм.

Орон нутгийг хөгжүүлэх асуудал нь төрийн бодлогын үндсэн нэг чиглэл байсаар ирлээ. Увс аймгийн хөгжлийн гарц, ерөнхий зураглал гаргах, Увс аймаг юун дээр тулгуурлаж хөгжих вэ? хөгжилд хүргэх ТОП-5 салбар юу байх вэ? зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх, салбарыг тодорхойлох зэрэг ажил

<sup>1</sup> Эдийн засгийн ухааны доктор, Монголбанкны Ерөнхий эдийн засагч.

Цахим шуудан: doojav\_ganochir@mongolbank.mn


Энэхүү судалгааны өгүүлэл бичихэд мэдээлэл бэлтгэн тусалсан С.Билгүүн, А.Ананд, Б.Ананд болон Х.Адил нарт талархал илэрхийлье. Энд дурдагдах аливаа санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

2014-2016 онд яригдаж байсан бол 2016 оноос хойш “Баруун бүсийн хувийн хэвшлийг дэмжих стратеги”, “Бүс нутагт нэмүү өртөг шингэсэн үйл ажиллагааг дэмжих” зэрэг асуудалд ихээхэн анхаарал хандуулж байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилт, дэмжлэгээр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд баруун бүсийн таван аймгийн эдийн засгийн өрсөлдөх чадвар, бэлэн байдлын үнэлгээг хийж, Увс аймагт үр тарианы аж ахуйн бизнес төлөвлөгөөг боловсруулж хүлээлгэн өгсөн мэдээлэл бий. Түүнчлэн баруун бүсийн хувийн хэвшлийг дэмжихэд нэн тэргүүнд засаглалын таатай орчныг бүрдүүлэх, хувийн хэвшлийг чадавхжуулах, дэд бүтцээ богино хугацаанд хөгжүүлэх нь зүйтэй гэдгийг зөвлөж байв. Үүний зэрэгцээ “Увс аймгийг хөгжүүлэх хэтийн зорилт” бодлогын баримт бичиг, “Увс аймагт аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөр 2017-2021”-ийг батлан хэрэгжүүлж байна.

Орон нутгийг хөгжүүлэх төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд газар нутаг, бүсийн онцлогт тохируулж, ул суурьтай судалгаанд суурилсан байх нь туйлын чухал билээ. Ялангуяа, энэ бодлого, стратеги нь үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны давхцыг арилгах, шинээр үйлдвэрлэл эрхлэгчдэд зах зээл, нөхцөл боломжийн талаарх урьдчилсан мэдээлэл өгөх, үр өгөөжтэй, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр дэмжлэг туслалцаа үзүүлэх учиртай.

Зураг 1

### Орон нутгийн хөгжлийн бодлогын цөм



Эх сурвалж: Судлаачийн зураглал

Сайн засаглал, бизнесийн таатай орчин, эдийн засгийн чадавхи болон сайн дэд бүтэц нь тухайн аймагт эдийн засгийн боломжийг бий болгож, өрсөлдөх чадварыг бүрдүүлнэ. Өрсөлдөх чадвар сайтай аймагт эдийн засгийн өндөр үр ашиг, бүтээмж өндөр байх тул хувийн хөрөнгө оруулалт орж, бизнес хөгжиж, ажил эрхлэлт, орлого нэмэгдэнэ. Улмаар эдийн засаг нь төрөлжиж, орлогын тогтвортой байдал хангагдана. Чанартай ажлын байртай, орлоготой иргэд нь нийгмийн капиталыг бүрдүүлж, улмаар засаглал, институцийн тогтолцоо бэхжиж, байгаль орчны асуудалд анхаарлаа хандуулна. Эдгээрийн дүнд орон нутаг дахь амьдралын чанар дээшилж, хөдөөнөөс хот руу бус, магадгүй хотоос хөдөө рүү чиглэсэн шилжих хөдөлгөөн ч идэвхжих боломжтой. Бизнесийг дэмжих, дэд бүтцийг байгуулахад санхүүжилт шаардлагатай, энэ нь төсвийн, хувийн хэвшлийн болон төрийн, хамтарсан хэлбэртэй байх ёстой болно. Гэхдээ энэ бүдүүвч амжилттай хэрэгжихэд санхүүжилтийн бус хүчин зүйл нь мөн адил чухал үүрэгтэйг онцлох нь зүйтэй юм. Дан ганц санхүүжилтийг чухалчлах нь богино хугацаанд л үр дүнтэй мэт боловч, урт хугацааны тогтвортой орлогыг бий болгох, суурь орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх алсын том зорилгод хүрч чадахгүй буюу үр дүнгүй болгох эрсдэлтэй юм. Үүний зэрэгцээ орон нутгийн хөгжлийн төлөөх идэвх чармайлтыг төрөөс болон төрийн бус байгууллагын зүгээс хэрхэн дэмжих, тэдгээрийн үүрэг нь хаана, ямар хэлбэр (хөрөнгө оруулалт, татварын хөнгөлөлт, татаас)-тэй байх нь анхнаасаа тодорхой байх нь чухал юм.

Дараагийн хэсгүүдэд Зураг 1-д харуулсан бүдүүвчийн дагуу Увс аймгийн хувьд өрсөлдөх чадварын үнэлгээ ямар байгаа, түүнд нөлөөлөгч хүчин зүйлд гарч буй өөрчлөлт, санхүүжилтийн болон бизнесийн орчин, тэдгээр дэх боломж, сорилтыг дэлгэрэнгүй авч үзлээ.

## **2. Увс аймгийн өрсөлдөх чадвар**

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн Азийн сантай хамтран 2012 оноос хойш жил бүр хийж буй “Аймгуудын өрсөлдөх чадварын судалгааны тайлан”-г ашиглаж, Увс аймгийн өрсөлдөх чадвар, түүнд гарч буй өөрчлөлтийг судаллаа. Тус судалгааны зорилго нь Монгол Улсын 21 аймгийн хөгжлийн түвшинг харьцуулан үнэлэх, аймгийн өрсөлдөх чадварыг цогц байдлаар тодорхойлох явдал юм. Судалгаагаар аймаг бүрийн хөгжлийн давуу ба сул талыг тогтоож, өрсөлдөх чадварын боломж, чадавхийг үнэлэн тогтвортой, урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулахад ашиглахуйц өргөн хүрээний мэдээллийн санг бүрдүүлж байна.


Энэ судалгааны хүрээнд аймгийн өрсөлдөх чадварыг үнэлэхдээ эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг болон дэд бүтэц гэсэн үндсэн дөрвөн бүлэгт багтах 180 шалгуур үзүүлэлтийг ашигладаг байна. Аймгуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулж, өрсөлдөх чадварын чиг

хандлагыг тодорхойлохоос гадна тухайн аймгийн өрсөлдөх чадварыг хойш татаж буй, эсвэл дээшлүүлж буй үзүүлэлтийг тогтоож, өрсөлдөх чадварын давуу, сул талыг үнэлэх боломж олгож буй нь энэхүү судалгааны давуу тал юм. Ингэснээр тухай аймаг яагаад өрсөлдөх чадварын хувьд бусдаас сайн, эсвэл сул байгааг ойлгож мэдэх, тухайн аймаг давуу талаа хэрхэн ашиглах, хөгжлийг хойш татаж буй сул талаа хэрхэн шийдвэрлэх шийдлийг олоход чухал мэдээлэл өгч байна.

Увс аймгийн өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ 2015-2018 онд 66-аас 76 (нийт 100 онооноос) болж өссөн бөгөөд нийт аймгийн дунджаас өндөр байсаар иржээ (Зураг 2).

Зураг 2

Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ



Зураг 3

Өрсөлдөх чадварын эрэмбэ




Эх сурвалж: Монгол Улс: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан. 2015-2018

Гэхдээ ерөнхий үнэлгээний оноо бусад аймагтай адил сүүлийн жилүүдэд хэлбэлзэл өндөртэй байгаа бөгөөд 2016-2017 онд буурсан бол 2018 онд эргэн хүчтэй нэмэгдсэн нь тус үзүүлэлт эдийн засгийн ерөнхий төлөвтэй эерэг хамааралтай гэсэн дүр зураг ажиглагдаж байна.

Зураг 4

Увс аймгийн өрсөлдөх чадварын үндсэн хүчин зүйлийн оноо




Эх сурвалж: Монгол Улс: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан 2018.

Харин өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээнд суурилан аймгийг эрэмбэлсэн үзүүлэлтээр Увс аймаг 2015 онд 8-д байсан бол 2017, 2018 онд 11 дүгээр байранд жагссан байна (Зураг 3). Энэ нь аймгийн өрсөлдөх чадвар ерөнхийдөө сайжирч байгаа хэдий ч зарим аймагтай харьцуулахад өрсөлдөх чадварын өсөлт сул байсныг илтгэж байна. Гэхдээ өрсөлдөх чадварын үзүүлэлтээр баруун бүсэд тэргүүлжээ.

Увс аймгийн өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ 2018 оны тайлангаар 76 оноо авч, 11-д эрэмблэгдэхэд ямар хүчин зүйл нөлөөлснийг тодорхойлохын тулд индексийг тооцоход ашиглаж буй бүрдлийг авч үзэх ёстой болно. Зураг 4-т үзүүлснээр Увс аймгийн эдийн засгийн тамир тэнхээ болон засаглалын үр ашгийн үзүүлэлт улсын дундаж орчим байгаа бол бизнесийн үр ашиг болон дэд бүтцийн үзүүлэлт улсын дунджаас өндөр байна. Ялангуяа, эдийн засаг болон хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт харгалзан 11 болон 16-д эрэмбэлэгдэж, аймгийн төсөв болон институцийн тогтолцоо 15 болон 14-т эрэмбэлэгдэж байгаа нь өрсөлдөх чадварын эрэмбийг хойш нь татаж байна. Харин хүн амын амьжиргааны түвшин (ядуурлын түвшин бусад аймагтай харьцуулахад бага), бизнесийн санхүү, технологийн дэд бүтэц, шинжлэх ухаан, боловсрол соёлын үзүүлэлт нь өрсөлдөх чадварын эрэмбэ харьцангуй өндөр байхад нөлөөлж байна (Зураг 5).

Зураг 5

Увс аймгийн өрсөлдөх чадварын төлөв байдал (эрэмбээр)



Эх сурвалж: Монгол Улс: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан 2018

Увс аймгийн өрсөлдөх чадварыг тодорхойлж буй үндсэн дөрвөн хүчин зүйл, тэдгээрийн доторх дэд үзүүлэлт цаг хугацааны туршид хэрхэн өөрчлөгдөж ирсэнийг дараах хэсэгт шинжлэн үзлээ.

Эдийн засгийн тамир тэнхээ. Увс аймгийн эдийн засгийн ерөнхий чадавх, зах зээлийн багтаамжийг илтгэдэг тус үзүүлэлт Увс аймгийн хувьд 2015-2018 онд 55-63 байгаа нь улсын дунджаас өндөр түвшинд байв. 2017 оны тайлан (2016 оны статистик мэдээлэл ашигласан)-гийн үзүүлэлтээр энэхүү үзүүлэлт 55 болж, 3.5 нэгж оноогоор буурсан хэдий ч улсын дундаж 8 нэгж оноогоор буурсантай харьцуулахад бага байна. Харин эдийн засаг 2017 оноос хойш сэргэсэнээр тус үзүүлэлт эргээд сэргэсэн байна (Зураг 6).

Зураг 6

Хүснэгт 1

Эдийн засгийн тамир тэнхээ

Дэд үзүүлэлтийн эрэмбэ



	Увс аймаг			
	2015	2016	2017	2018
Эдийн засгийн тамир тэнхээ	13	12	11	10
Эдийн засаг	19	17	11	11
Эдийн засгийн салбарууд	11	10	13	9
Хүн амын амьжиргааны түвшин	3	6	8	7
Хөдөлмөр эрхлэлт	19	14	17	16

Эх сурвалж: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан, 2015-2018

Увс аймгийн эдийн засгийн тамир тэнхээний эрэмбэ сүүлийн дөрвөн жил дараалан өслөө. Үүнд эдийн засгийн үзүүлэлт сайжирсан, эдийн засгийн салбарын үзүүлэлт дээшилсэн болон хүн амын амьжиргааны түвшин харьцангуй өндөр хэвээр байгаа зэрэг нь нөлөөлжээ. Гэхдээ хүн амын амьжиргааны түвшний үзүүлэлт сүүлийн дөрвөн жилд дараалан буурсан байна. Харин хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт улсын хэмжээнд туйлын доогуур түвшинд буюу эрэмбээрээ сүүлийн таван аймагт жагссаар байна. Увс аймгийн хувьд ногоон эдийн засгийн талаарх ойлголт, эдийн засгийн төрөлжилт, ажиллах хүчний оролцооны түвшин, хадгаламж, ажлын байрны хүрэлцээ болон тариалсан талбай зэрэг үзүүлэлт нь улсад дээгүүр байж, давуу тал бий болгож байна. Харин хүн амын ачаалал өндөр, нэг хүнд ногдох ДНБ бага, дундаж цалин доогуур, ажилгүйчүүдийн тоо өндөр, хөдөлмөр эрхлэлтийн түвшин бага, эдийн засгийн багтаамж бага, хэрэглээний үнийн өсөлт өндөр зэрэг нь сул тал болж байна.

Засаглалын үр ашиг. Засаглалын үр ашгийн үнэлгээ Увс аймагт улсын дунджаас өндөр байсаар иржээ. Тус үнэлгээ эдийн засгийн мөчлөгтэй мөн адил чиглэлд хөдөлж байгаа буюу 2017 онд (2016 оны статистик мэдээлэлд суурилсан) улсын дундаж, тус аймгийн үзүүлэлтийн аль аль нь буурч, 2018 онд эргэн өссөн байна. Гэхдээ 2018 онд тус аймгийн үзүүлэлт, улсын дунджийн хоорондын зөрүү 16 нэгжид хүрч нэмэгдсэн байна (Зураг 7). Тус аймгийн засаглалын үр

ашгийн үнэлгээ 2015-2017 онд сайжрахад институцийн тогтолцоо, нийгмийн тогтолцооны үзүүлэлт чухал үүрэг гүйцэтгэсэн бол 2018 оны тайланд сайн хэвээр гарах (нийт дүнгээр 13 дугаар байранд жагсах)-д өмнөх хоёр жилд хамгийн муу эрэмбэ байсан аймгийн төсвийн өрсөлдөх чадвар огцом сайжирч, 13-т эрэмбэлэгдэх болсон нь гол үүрэг гүйцэтгэжээ (Хүснэгт 2).

Зураг 7

Хүснэгт 2



Дэд үзүүлэлтийн эрэмбэ

	Увс аймаг			
	2015	2016	2017	2018
Засаглалын үр ашиг	20	15	13	13
Аймгийн төсөв	11	21	21	15
Институцийн тогтолцоо	14	21	16	14
Бизнесийн эрх зүй	8	8	10	10
Нийгмийн тогтолцоо	20	1	5	10

Эх сурвалж: Монгол Улс: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан. 2015-2018

Аймгийн төсвийн болон институцийн өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Увс аймаг 2016 онд хамгийн сүүлд эрэмбэлэгдэж байсан бол нийгмийн тогтолцооны үзүүлэлтээр 1-д, бизнесийн эрх зүйн орчны үзүүлэлтээр 8-д эрэмбэлэгдэж, 2016 оноос хойш институцийн тогтолцооны өрсөлдөх чадвар сайжирч, харин бизнесийн эрх зүй, нийгмийн тогтолцоо нь муудаж байна. Хууль ёсны хэрэгжилт сул, аймгийн удирдлагын бодлого, шийдвэр сул, ил тод байдал хангалтгүй, татвараас зайлсхийх байдал болон төсвийн эрх мэдэл бага зэрэг нь засаглалын үр ашиг харьцангуй сул байх хүчин зүйл болж байна.

Зураг 8

Хүснэгт 3

Бизнесийн үр ашгийн үнэлгээ

Дэд үзүүлэлтүүдийн эрэмбэ



	Увс аймаг			
	2015	2016	2017	2018
Бизнесийн үр ашиг	3	7	6	6
Бизнесийн орчин	9	9	7	9
Хөдөлмөрийн зах зээл, бүтээмж	12	19	8	9
Санхүү	2	1	3	5
Менежментийн хэвшил	2	8	12	14


Эх сурвалж: Монгол Улс: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан. 2015-2018

Бизнесийн үр ашиг. Тухайн аймгийн бизнесийн орчин, хөдөлмөрийн зах зээл, бүтээмжийг илтгэдэг тус үнэлгээ Увс аймгийн хувьд маш сайн буюу улсын дунджаас бараг хоёр дахин өндөр явж иржээ (Зураг 8). Гэхдээ 2015 онд 91.58 оноо авч байсан аймгууд дотроо 3-т эрэмбэлэгдэж байсан дэд үзүүлэлт сүүлийн жилүүдэд тасралтгүй буурсаар 2018 онд 73.5 болж буурч, улсад 6-д эрбэмбэлэгдэх болоод байна. Хөдөлмөрийн зах зээлийн өрсөлдөх чадвар 2015 онд 12-д, санхүүгийн өрсөлдөх чадварын болон менежментийн хэвшлийн дэд үзүүлэлтээр 2-т эрэмбэлэгдэж байсан бол менежментийн хэвшлийн үзүүлэлтийн эрэмбэ муудаж 14-т хүрч, хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтийн эрэмбэ сайжирч 9-д хүрсэн байна (Хүснэгт 3). Зээл, хадгаламжийн үлдэгдэл өндөр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн тоо харьцангуй олон зэрэг нь тус аймгийн давуу тал болж байна. Харин чанаргүй зээлийн үлдэгдэл өндөр, банкны салбарын активын өсөлт бага, хөдөлмөрийн бүтээмж бага, зээл авах боломж хязгаарлагдмал зэрэг нь сул тал болж байна.

Дэд бүтэц. Увс аймгийн хувьд дэд бүтцийн үнэлгээ улсын дунджаас өндөр байж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд байнга сайжирчээ (Зураг 9). 2015 оны тайланд 13-т эрэмбэлэгдэж байсан тус үнэлгээ 2018 оны тайланд 4-т эрэмбэлэгдэх болжээ. Ийнхүү дэд бүтцийн өрсөлдөх чадвар нэмэгдэхэд технологи, үндсэн дэд бүтэц, боловсрол, соёл болон эрүүл мэнд хүрээлэн буй орчин гээд бүхий л чиглэлд ахиц дэвшил жигд гарсан нь нөлөөлжээ. Тухайлбал, 2015, 2018 онд үндсэн дэд бүтцийн үзүүлэлт 4, технологийн дэд бүтцийн дэд үзүүлэлт 4, эрүүл мэнд хүрээлэн буй орчны үзүүлэлт 5 байраар тус тус урагшилсан байна (Хүснэгт 4). Харин боловсрол, соёлын өрсөлдөх чадварын дэд үзүүлэлтийн эрэмбийн хэлбэлзэл өндөр байгаа бөгөөд 2016 онд нийт аймгийн хэмжээнд тэргүүлж байсан бол 2017 онд 15-д эрэмбэлэгдэх болж, харин 2018 онд эргээд 6-д эрэмбэлэгдэх болжээ.

Зураг 9

Дэд бүтцийн үнэлгээ



Хүснэгт 4

Дэд үзүүлэлтийн үнэлгээ

	Увс аймаг			
	2015	2016	2017	2018
Дэд бүтэц	13	9	7	4
Үндсэн дэд бүтэц	16	13	11	12
Технологийн дэд бүтэц	12	8	8	6
Боловсрол, соёл	4	1	15	6
Эрүүл мэнд, хүрээлэн буй орчин	13	15	5	8

Эх сурвалж: Монгол Улс: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан, 2015-2018.



Бусад аймагтай харьцуулахад, эхийн эндэгдлийн түвшин бага, цахилгааны үнэ хямд, мэдээллийн байгууллага сайтай, тээврийн хөгжил сайн, хүн амын цэвэр өсөлт өндөр, урлагийн байгууллагын үзэгчдийн тоо олон, шинийг санаачлах чадвар өндөр зэрэг нь давуу тал болж байна. Харин сургуулийн өмнөх боловсрол хангалтгүй, цэцэрлэгийн сурагч/багшийн харьцаа өндөр, нялхсын эндэгдлийн түвшин өндөр, шатахууны үнэ өндөр, нийслэлээс алслагдсан, их эмчийн тоо цөөн, замын чанар хангалтгүй, дундаж наслалт бага зэрэг нь сул тал болж байна.


Увс аймгийн өрсөлдөх чадварын үнэлгээг нэгтгэн үзэхэд, сургуулийн өмнөх боловсролын чанарыг сайжруулах, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх, аймгийн хэмжээнд чанаргүй зээл өндөр байгааг бууруулах, аймгийн удирдлагын бодлого, шийдвэрийн ил тод байдлыг сайжруулах, чанартай ажлын байрыг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар ажил эрхлэлт, бүтээмж, орлогыг нэмэгдүүлэх, үүний тулд төсвийн болон хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх болон нийслэлээс алслагдсан байдлаас үүдэлтэй нэмэлт зардлыг бууруулах, түүнийг нөхөхөд шаардлагатай татварын хөнгөлөлт үзүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

### 3. Увс аймаг дахь санхүүгийн зах зээл


Тус аймгийн санхүүгийн зах зээлийн үнэлгээг хийхдээ Монголбанкнаас албан ёсоор гаргадаг орон нутгийн зээл, хадгаламж болон ипотекийн зээлийн тайлангийн мэдээллийг суурь болгон ашиглалаа.

Увс аймагт 2019 оны хоёрдугаар сарын байдлаар арилжааны 5 банк (Хаан, Төр, Хас, Голомт болон Капитал)-ны салбар үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд банкны салбарт нийт 281 ажилтан ажиллаж байна (Зураг 10).

Зураг 10



Зураг 11




Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо

Харин үнэт цаасны компани (УЦК) 1, Хөдөө аж ахуйн биржид бүртгэлтэй брокер (ХААБ брокер) 1, банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) 2, хадгаламж зээлийн 7 хоршоо (ХЗХ) үйл ажиллагаа явуулж байна (Зураг 11).

Банкны салбарын харилцах, хадгаламж. 2019 оны хоёрдугаар сарын байдлаар Увс аймгийн хэмжээнд хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 15.0 хувиар өсч, 108.3 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт хадгаламжийн 78.8 хувь буюу 85.4 тэрбум төгрөг нь хугацаатай хадгаламж, 99.6 хувь нь төгрөгийн хадгаламж байна. Нийт хадгаламжийн 98.7 хувь буюу 106.9 тэрбум төгрөг нь иргэдийн хадгаламж байна. Аймгийн иргэдийн хадгаламжийн 20 хувь нь хугацаагүй, 50 хувь нь 3 хүртэл сарын хугацаатай хадгаламж байгаа бол үлдсэн 30 хувь нь 3 сараас дээш хугацаатай хадгаламж байна (Зураг 12).

Зураг 12



Эх сурвалж: Монголбанк

Увс аймгийн хувьд нийт 11.8 тэрбум төгрөгийн харилцахын 11.6 тэрбум нь төгрөгөөр байршиж байна. Ерөнхийдөө уул уурхайн үйлдвэрлэл, газар тариалангийн үйлдвэрлэл болон хүн ам ихээр төвлөрсөн болон томоохон хилийн боомттой аймгийн харилцах дансны үлдэгдэл бусад аймагтай харьцуулахад харьцангуй өндөр байдаг. Увс аймгийн хувьд эдгээр шинж тэмдэгт хамаарахгүй тул харилцахын үлдэгдлээр 21 аймгаас 18-д эрэмбэлэгдэж байна (Зураг 13).

Увс аймгийн хэмжээнд 2019 оны хоёрдугаар сарын байдлаар нийт 2.1 тэрбум төгрөгийн хадгаламж шинээр татан төвлөрүүлж, энэ үзүүлэлтээр 21 аймгаас 8-д эрэмбэлэгдэж байна (Зураг 14).

Зураг 13



Зураг 14




Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын зээл. 2019 оны хоёрдугаар сарын байдлаар Увс аймагт 33325 зээлийн дансны 195.2 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 12 хувиар өссөн үзүүлэлт юм (Зураг 15). Аймгийн хэмжээнд 855 зээлийн дансны 17.4 тэрбум төгрөг нь төслийн зээлийн үлдэгдэл байна. Гадаад валютаар олгосон гурван зээлийн дансны 203.2 сая төгрөгийн үлдэгдэл байна. Аймгийн нийт зээлийн 88 хувийг иргэдэд, 7 хувийг хувийн хэвшлийн байгууллагад олгожээ.


2019 он гарснаас хойш зээлийн төлөлт нь олголтоос өндөр байна (Зураг 16). Өөрөөр хэлбэл, энэ оны эхнээс макро зохистой бодлогын хүрээнд хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувиар тогтоож, тус зээлийн хугацааг 30 сараас хэтрэхгүй байхаар тогтоосны нөлөө байж болохоор байна. Энэ нь тус аймгийн зээлийн гол эрэлт нь хэрэглээний зээл дээр төвлөрдөг болохыг давхар илтгэж байна.

Аймгийн түвшинд депозит (харилцах, хадгаламжийн нийлбэр) болон зээлийн харьцааг тооцоход 0.61 гарч байгаа буюу аймаг нь өөрийн хуримтлалаас хэт давсан зээлийг авч ашиглаж байна.

Зураг 15




Зураг 16



Эх сурвалж: Монголбанк

Увс аймгийн нийт зээлийн бүтцийг авч үзвэл, 56.5 хувийг хэрэглээний зээл буюу цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан, картын болон автомашины зээл бүрдүүлж байна. Хэрэглээний зээлийн 91.1 хувийг цалин, тэтгэврийн зээл дангаар бүрдүүлжээ (Зураг 17). Өөрөөр хэлбэл, зээлийн эх үүсвэр нь бизнесийг дэмжих, ажлын байр, орлогын нэмэгдүүлэхэд бус зөвхөн өрхийн орон сууц худалдан авах, хэрэглээг санхүүжүүлэхэд зориулагдаж байна.

Зураг 17



Эх сурвалж: Монголбанк

Аймгийн нийт зээлийн 5.5 хувь буюу 10.7 тэрбум төгрөг нь чанаргүй зээлд ангилагдаж байгаа нь орон нутгийн хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт юм. Хугацаа хэтэрсэн зээлийн хувьд 2.8 тэрбум төгрөг буюу нийт зээлийн 1.4 хувь байна. Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл нь нийт зээлийн 6.9 хувь байгаагаас үзэхэд зээлийн эрсдэл өндөртэй аймаг болж байна (Зураг 18). Чанаргүй зээлийн бүтцийг үзвэл, худалдаа, үйлчилгээ, боловсруулах салбарт олгосон болон цалин, тэтгэврийн зээл дийлэнх хувийг бүрдүүлж байна (Зураг 19).

Зураг 18

Зураг 19

Чанаргүй зээлийн эзлэх хувь



Увс аймгийн чанаргүй зээлийн бүтэц




Эх сурвалж: Монголбанк

Хадгаламж, зээлийн хүү. Увс аймаг дахь үлдэгдлээр жигнэсэн төгрөгийн хадгаламжийн хүү (ЖДХ) 11.9 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 3.7 байгаа нь улсын дунджаас харгалзан 0.1 болон 1.6 нэгж хувиар тус тус бага байна. Увс аймагт шинээр татсан төгрөгийн ЖДХ 9.7 хувь, гадаад валютын ЖДХ 0.6 хувьтай байна (Зураг 21).

Увс аймгийн төгрөгөөр татсан хадгаламжийн үлдэгдлийн ЖДХ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.0 нэгж хувиар, тухайн сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү 3.5 нэгж хувиар тус тус буурсан байна. Харин гадаад валютын ЖДХ мөн харгалзан 3.7 нэгж хувь болон 0.6 нэгж хувиар буурчээ.

Зураг 20



Зураг 21



Эх сурвалж: Монголбанк

Увс аймгийн хэмжээнд тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа 24.2 сар, төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 20.4 хувьтай байгаа аймгуудаас 10-т эрэмбэлэгдэж байгаа нь улсын дунджаас 3.3 нэгж хувиар өндөр үзүүлэлт юм (Зураг 22).

Зураг 22



Зураг 23



Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон зээлийн хүү сүүлийн хоёр сард 2.4 нэгж хувиар өсч, 20.4 хувьд хүрсэн нь чанаргүй зээл өндөр байгааг харгалзан зээлийн эрсдэлийг тодорхой түвшинд хүүнд шингээж байгааг илтгэж болно (Зураг 23).


Увс аймагт зээлийн үлдэгдлийн ЖДХ-ний хувьд төгрөгөөр олгосон зээлийн ЖДХ бусад аймагтай харьцуулахад хамгийн бага буюу 17.3 хувь эсрэгээр гадаад валютаар олгосон зээлийн ЖДХ хамгийн өндөр буюу 18 хувьтай байна. Аймгийн төгрөгөөр олгосон зээлийн үлдэгдлээрх ЖДХ өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар буурчээ.

Ипотекийн зээл. Нийт ипотекийн зээлийн 933.3 тэрбум төгрөг буюу 21.1 хувь нь орон нутаг дахь банкны салбараас олгосон зээл байгаа бол худалдан авсан орон сууцны байршлаар нь авч үзвэл, нийт зээлийн 17.2 хувь болох 757.0 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна.

Увс аймагт 1272 зээлдэгчийн 40.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийн үлдэгдэл байна (Зураг 24).


Зураг 24

Ипотекийн зээл  
(аймгуудаар)



Зураг 25

Ипотекийн зээлийн эх үүсвэр




Эх сурвалж: Монголбанк

Увс аймгийн нийт ипотекийн зээлийн 78.7 хувь нь Засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд, 20.9 хувь нь банкны өөрийн эх үүсвэрээс олгогджээ (Зураг 26).

Зураг 26

Санхүүжилтийн эх үүсвэр


- Банкны өөрийн эх үүсвэрийн зээл
- Хөтөлбөрийн зээл (8%, 5%)
- Бусад



тэрбум ₮

Зураг 27

Увс аймагт олгосон зээл



Эх сурвалж: Монголбанк

Увс аймагт 2019 оны хоёрдугаар сард орон сууцны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд гурван зээлдэгчийн 165 сая төгрөгийн зээл, банкны эх үүсвэрээр нэг зээлдэгчийн 59 сая төгрөгийн зээл олгогдсон байна.

**4. Увс аймаг дахь ЖДҮ-ийн бизнесийн орчин**

Монголбанк сүүлийн зургаан жил дараалан улсын хэмжээнд “Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал” түүвэр судалгааг хийж ирсэн. Энэ хэсэгт 2018 оны есдүгээр сард хийж гүйцэтгэсэн тус түүвэр судалгааны мэдээллийн санг ашиглан Увс аймагт бизнесийн орчин, түүний санхүүжилт ямар байгааг авч үзлээ.


Увс аймагт 2018 оны дөрөвдүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 1559 ААН-ээс санамсаргүй түүврийн аргаар 64 жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчдийг судалгаанд хамруулжээ. Түүвэрлэлийн газар зүйн байршлыг Хавсралтад харууллаа.

Түүврийн ерөнхий мэдээлэл. Зураг 28-д судалгаанд хамрагдсан Увс аймгийн ЖДҮ эрхлэгчдийг аж ахуй нэгжийн хэлбэрээр нь ангилан харууллаа. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 69 хувь нь хувиараа, 28 хувь нь нөхөрлөл хэлбэрээр бизнес эрхэлдэг байна. Харин хувьцаат компани, хоршоо хэлбэрээр бизнес эрхлэгчдийн тоо аймгийн нийт түүвэрт тус бүр дөрвөн хувийг эзэлж байна.




Зураг 28

ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны хэлбэр  
(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Зураг 29

ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл  
(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх сурвалж: Монголбанк, 2018 оны ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан Увс аймгийн ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааг эрхэлж буй хэлбэрээр нь авч үзэхэд, 54 хувь нь үйлдвэрлэл, 19 хувь нь үйлчилгээ, 12 хувь нь худалдаа эрхэлдэг гэж хариулсан нь үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ эрхлэгч санал асуулганд түлхүү оролцсоноор бусад аймгийн бүтцээс онцлог байлаа.

Зураг 30-д ААН-ийн санхүүгийн тайлан гаргадаг эсэхийг харууллаа. Судалгааны үр дүнгээс харахад, Увс аймгийн түүвэр судалгаанд хамрагдсан ААН-ийн 47 хувь нь санхүүгийн тайлан гаргадаг бол 40 хувь нь тайлан гаргадаггүй гэж хариулсан нь улсын дунджаас бага зэрэг өндөр байна. Харин тайлан гаргахад бэрхшээлтэй байдаг гэж 12 хувь нь хариулжээ.


Зураг 30

ААН-ийн санхүүгийн тайлан  
(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Зураг 31

Үйл ажиллагаа эрхлэх лиценз  
(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх сурвалж: Монголбанк, 2018 оны ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 18 хувь нь үйл ажиллагаа явуулах лицензтэй байгаа бол 65 хувь нь лиценз байхгүй, үлдсэн 18 хувь нь бизнес эрхлэх лиценз авахаар ажиллаж байна (Зураг 31).

Дэмжлэг. Зураг 32-т Увс аймгийн ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлдэг байгууллагыг харуулж байна. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх (30 хувь) нь арилжааны банк ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг гэж хариуллаа. Түүний дараагаар орон нутгийн засаг захиргаа, санхүүгийн бусад байгууллага, худалдаа, аж үйлдвэрийн танхим, Засгийн газар зэрэг байгууллага орлоо. Увс аймгийн хувьд орон нутгийн засаг захиргаа дэмждэг гэдэг үзүүлэлт улсын дундажтай харьцуулахад мэдэгдэхүйц өндөр байна.

Зураг 32

ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй байгууллага  
(Санал асуугад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх сурвалж: Монголбанк, 2018 оны ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зураг 33-т ЖДҮ эрхлэгчдэд хамгийн ихээр ирдэг дэмжлэгийг харуулж байна. Увс аймагт ЖДҮ эрхлэгчдэд голлон санхүүжилт олгох дэмжлэг үзүүлдэг гэж үзсэн нь улсын дундажтай ойролцоо байна. Харин үзэсгэлэн худалдаа зохион байгуулдаг болон ЖДҮ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлдэг гэсэн хариулсан хувь хэмжээ улсын дунджаас мэдэгдэхүйц өндөр байна.

Зураг 33

ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэг

(Санал асуулгад оролцогчийн эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх сурвалж: Монголбанк, 2018 оны ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зураг 34-т ЖДҮ эрхлэгчдийн зүгээс цаашид тэдний үйл ажиллагааг дэмжихийн тулд төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг харууллаа. Санал асуулгын дүнгээр Увс аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 48 хувь нь цаашид нэн тэргүүнд бизнестэй холбоотой шийдвэрт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй гэж үзсэн бол 19 хувь нь хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг хүсчээ. Энэ хоёр хариулт улсын дундажтай харьцуулахад өндөр байна. Харин төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох шаардлагатай гэсэн хүсэлтийн хувьд улсын дунджаас бага хувьтай хариулсан байна.

Зураг 34

ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэг

(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)




Эх сурвалж: Монголбанк, 2018 оны ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Бизнесийн орчин. Увс аймагт үйл ажиллагаа эрхлэгч ЖДҮ-ийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлийг үндсэн зургаан бүлэг (орчин)-т хуваан авч үзлээ: Макро эдийн засгийн нөлөө; нийгэм, улс төрийн байдал; хХууль эрх зүй, төрийн зохицуулалт; зах зээлийн орчин; дэд бүтцийн хөгжил; санхүүжилтийн орчин зэрэг болно. Санал асуулгын дүнг нэгтгэж, Увс аймгийн бизнесийн орчны ерөнхий индексийг тооцоход, нийгэм, улс төрийн орчин (-0.73), санхүүжилтийн орчин (-0.74), макро эдийн засгийн орчин (-0.63) гэж тус тус гарсан нь улсын дундажтай харьцуулахад муу байна. Харин тус аймгийн бизнес эрхлэгчид дэд бүтцийн орчныг боломжийн сайн гэж үнэлжээ (Зураг 35).

Увс аймгийн улсын дунджаас хол зөрүүтэй байгаа хүчин зүйлийг авч үзэхэд, эдийн засгийн орчинд гадаадын шууд хөрөнгө оруулалт өндөр биш, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларч, инфляци өндөр байгаа нь сөрөг байхад нөлөөлж байна гэж үзсэн бол ажилгүйдэл, ядуурал өндөр, улс төрийн тогтворгүй байдал нь нийгэм, улс төрийн орчны сөрөг хүчин зүйл гэж үзжээ. Харин гадаад худалдаа хийх нөхцөл муу гэсэн хариулт нь хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчинд сөргөөр нөлөөлж байгаа гэсэн бол зах зээлийн багтаамж, хэрэглэгчийн худалдан авах чадвар муу байгаа нь зах зээлийн орчин сул байхад нөлөөлж байна гэж үзжээ. Зээлийн шимтгэл, хураамж өндөр, зээлийн хугацаа богино, зээлийн хүү өндөр байгаа нь санхүүжилтийн орчин муу байхад нөлөөлж байна гэж хариулжээ. Харин дулааны шугам, сүлжээ болон замаас бусад дэд бүтцийн орчин маш сайн гэж хариулсан үр дүн гарчээ (*Хавсралтыг харна уу*).

Зураг 35



Эх сурвалж: Монголбанк, 2018 оны ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

ЖДҮ эрхлэгчдийн зардлын байдал. Увс аймгийн судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн хувьд улсын дундажтай харьцуулахад хамгийн хүндрэлтэй зардалд зээлийн хүүний зардал, банкны хураамж, шимтгэлийн зардал орж

байгаа бол удаах зардалд үйл ажиллагааны зардал, цахилгааны зардал болон түүхий эдийн зардал орж байна.

Зураг 36




Эх сурвалж: Монголбанк, 2018 оны ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Харин тус аймгийн бизнес эрхлэгчид түрээсийн зардлыг улсын дундажтай харьцуулахад харьцангуй бага хүндрэлтэй гэж хариулжээ. Бусад бүх зардлын хувьд улсын дунджаас илүү хүндрэлтэй гэж хариулсан нь нийслэлээс алслагдсан тул шатахуун, тээврийн зардал өндөртэй байдгаар тайлбарлагдаж болох юм.

Санхүүжилтийн хэрэгцээ, шаардлага. Увс аймгийн ЖДҮ бизнес эрхлэгчдийн дийлэнх буюу 89 хувь нь ирэх нэг жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхлэхэд нь санхүүжилт зайлшгүй хэрэгцээтэй байна гэж үзсэн байхад 11 хувь нь санхүүжилт авах шаардлагагүй гэж хариулжээ (Зураг 37).


Зураг 37

**Санхүүжилт авах хэрэгцээ**  
(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Зураг 38

**Санхүүжилтийн эх үүсвэр**  
(Санал асуулгад оролцогчдын эзлэх хувь, давхардсан тоогоор)



Эх сурвалж: Монголбанк, 2018 оны ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Түүнчлэн ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь буюу 68 хувь нь бизнесийн үйл ажиллагаа явуулахад нь 50 хүртэлх сая төгрөгийн санхүүжилт, 91 хувь нь 100 хүртэлх сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна гэж хариулжээ (Зураг 38).

## **5. Дүгнэлт, зөвлөмж**

Орон нутгийн хөгжлийн бодлого, стратеги нь өөрийн бүс нутгийн онцлог, мэдлэг, туршлага, итгэл, үнэмшлийг бүрэн шингээсэн, доороос дээшээ чиглэлтэй санал, санаачлагад тулгуурласан, олон талыг хамарсан (*хүнсний нийлүүлэлтийн хэлхээ, байгаль, орчны асуудал, орон нутгийн эдийн засгийг төрөлжүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх зэргийг багтаасан*) бүрэн тогтолцоо бүрдүүлэх, орон нутгийн өрсөлдөх чадварыг сайжруулах замаар иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх том зорилтод чиглэсэн байх нь илүү үр дүнтэй юм.

Увс аймгийн хувьд өрсөлдөх чадвар улсын дунджийн орчим (*дэд бүтэц, бизнесийн орчны хувьд өрсөлдөх чадвар сайтай, эдийн засгийн чадал тэнхээ болон засаглалын үр ашгийн хувьд тааруу*), зуучлал, зах зээлийн хувьд дундаж түвшинд, гэхдээ зээлийн эрсдэл, түүнийг дагаад зээлийн хүү өндөр байгаа бол бизнесийн орчны хувьд зардал өндөртэй, зах зээлийн багтаамж багатай, ажилгүйдэл өндөртэйгээс худалдан авах чадвар султай гэсэн дүр зураг харагдаж байна. Ийнхүү дундаж түвшинд байгаа нь хийж бүтээн, амжилтанд хүрч байгаа олон ажил байгаа хэдий ч, мөн илүү анхаарал хандуулах замаар аймаг, орон нутгийг илүү хурдацтай хөгжүүлэх боломж байгааг илэрхийлж байна.

Орон нутгийн хөгжлийн стратегийн хувьд дэд бүтэц, бизнесийн орчны үр ашгийн сайн үзүүлэлтийг бататгаж, засаглалын үр ашгийг дээшлүүлэх замаар эдийн засгийн тамир тэнхээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх шаардлага байна. Дэд бүтцийн хөгжлийн хувьд дулааны шугам сүлжээг сайжруулах нь олон судалгаагаар нэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай асуудал гэж гарч байна. Үүний дараагаар замын асуудал нэрлэгдсэн хэвээр байна. Харин бусад дэд бүтцийн хувьд баримталж буй нээлттэй бодлогоо үргэлжлүүлэх нь зүйтэй. Бизнесийн орчны хувьд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, гадаад худалдаа хийх нөхцөлийг бүрдүүлэх, санхүүгийн болон бусад зардлыг бууруулах, зээлийн нөхцөл, шалгуурыг уян хатан болгох, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. Засаглалын үр ашгийн хувьд төрийн албан хаагчдыг чадавхижуулах, аймгийн бодлого бодлого болон төсвийн зарцуулалтын ил тод, нээлттэй байдлыг сайжруулах, хууль ёсны хэрэгжилтийг сайжруулах тал дээр онгой анхаарах шаардлагатай байна. Учир нь эдгээр үзүүлэлтээр бусад аймгаас сүүл мушгиж байна. Сайн засаглал, институци бүрдсэн цагт л хувийн хөрөнгө оруулалт орж, бизнесийн урт хугацааны түншлэл бий болдог жамтай. Дээрх гурван хүчин зүйлийн өрсөлдөх чадварыг өндөр түвшинд хангаж

чадсанаар бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, ажил эрхлэлт нэмэгдэж, орлого өссөнөөр эдийн засгийн тамир тэнхээ цаг хугацааны туршид сайжирна.

Гэхдээ хөгжлийг хурдасгахад төрийн зохистой зохицуулалт, зорилтот үр дүнтэй дэмжлэг чухал юм. Орон нутгийн бизнесийг дэмжих, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ нь өөрийн давуу талд тулгуурлах нь зүйтэй. Тухайлбал, тариалсан талбайн хэмжээ нэмэгдэж буй энэ үед үр тарианы аж ахуйн бизнес загварыг төгөлдөржүүлэх, худалдааны салбарын өргөжилтийг үргэлжлүүлэн дэмжих, өртгийг бууруулах, аж үйлдвэр, барилгын салбарын өргөжилтийг үргэлжлүүлэн хангаж, эдийн засгийн төрөлжилтийг дэмжих, байгаль, түүх, соёлын өвд түшиглэн аялал жуулчлалын салбарыг хөгжлийн дараагийн шатанд гаргах шаардлагатай байна.

Олон улсын, төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг одоогийн олон жижиг асуудлыг шийдвэрлэхэд бус, харин бүтээмжийг нэмэгдүүлсэн, урт хугацааны тогтвортой орлогын эх үүсвэр, хөгжлийн тулгуур болох салбарт чиглүүлэх нь чухал юм. Тухайлбал, өрсөлдөх чадварын судалгаанаас харахад, цэцэрлэг, сургуулийн хүрэлцээтэй байдлыг сайжруулах, сургалтын чанарыг дээшлүүлэх нь чухал байна. Ялангуяа, сургуулийн өмнөх насны хүүхдийн мэдлэг, чадавхи, боловсролд оруулсан хөрөнгө оруулалт хамгийн өндөр өгөөжтэй болохыг олон улсын судалгаанууд нотолж байна. Цэцэрлэг, сургууль барих төсвийн мөнгөөр үр дүнг хэмжих бус, ая тухтай орчинд сайн багшаар заалгаж, эрдэм сурч, зөв хүн болж төлөвшсөн багачууд Увс аймаг, цаашлаад Монгол Улсын ирээдүйг тодорхойлно. Хүний хөгжид хүрэх өөр нэг чухал, гэхдээ Увс аймгийн хувьд сул үзүүлэлттэй байгаа хүчин зүйл бол эрүүл мэндийн асуудал юм. Орон нутгийн хөгжлийн бодлого, үйл ажиллагаа нь иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулахад чиглэх учиртай.

**Ном зүй:**

- [1] Mikuš O., Franić R. and Grgić I. 2012, ‘The evaluation of rural competitiveness in creating a policy of rural development in Croatia’, Journal of Food, Agriculture and Environment, vol. 10, no. 2, pp. 962-969.
- [2] Монгол Улс: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан 2015, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ).
- [3] Монгол Улс: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан 2016, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ).
- [4] Монгол Улс: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан 2017, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ).
- [5] Монгол Улс: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан 2018, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ).
- [6] Монголбанк 2018, ‘Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал 2018’ судалгааны тайлан.
- [7] OECD 2018, ‘Rural 3.0. A Framework for rural development’, Policy note, Organisation for Economic Co-operation and Development.






*Хавсралт*

Түүвэрлэлтийн байршил, бизнесийн орчинд нөлөөлж буй хүчин зүйл  
Увс аймгаас судалгаа авсан түүвэрлэлтийн газар зүйн байршил



Бизнесийн орчинд нөлөөлж буй хүчин зүйл





Эх сурвалж: Монголбанк, 2018 оны ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн